



03/2021

Тархаасан: 2021 оны 4 дүгээр сарын 15

Үйлдвэрлэлийн осол, хурц хордлого өмнөх оны мөн үеэс 39-р буурлаа.




Мэргэжлийн хяналтын ерөнхий газрын мэдээллээр Үйлдвэрлэлийн осол, хурц хордлого 2021 оны эхний улиралд 45 бүртгэгдэж, өмнөх оны мөн үеэс 39 (46.4%-н тохиолдолоор, өмнөх улирлаас 69 (59.8%) бүүрсан байна. Эдгээр 45 тохиолдол бүгд үйлдвэрлэлийн осол байгаа ба хурц хордлогын тохиолдол гараагүй байна.

Үйлдвэрлэлийн ослын 14 (31.1%) тохиолдол унаж, бүдрэх, хальтарснаас үүссэн бол 8 (17.8%) нь эд зүйлд хавчуулагдах, 4 (8.9%) нь унаж байгаа эд зүйлд цохигдсоны, 4 (8.9%) нь хүчилсэн болон хүчтэй хөдөлгөөний, 3 (6.7%) нь халалт, түлэгдэлт, хөлдөлтийн, 2 (4.4%) нь гадны халдлагад өртсөний, 1 (2.2%) нь эд зүйл дээр гишгэсэн суурин болон хөдөлгөөнт эд зүйлд цохигдсоны улмаас, 9 (20.0%) нь бусад шалтгааны улмаас бүртгэгдсэн байна.


Нийт осолдогчдын 22 (48.9%) нь хөнгөн хэлбэрээр, 19 (42.2%) хүнд хэлбэрээр осолдож, 4 (8.9%) хүн нас барсан байна.

Зураг 1. Үйлдвэрлэлийн осол, хурц хордлого, бүсээр, жил бүрийн эхний улирлын байдлаар



Нийт осолдогчдын 17 (37.8%) нь эмэгтэйчүүд байна. Үйлдвэрлэлийн осол 2021 оны 1-р улиралд Төвийн бүсэд 12 (26.7%), Хангайн болон Баруун бүсэд тус бүр 4 (8.9%), Зүүн бүсэд 1 (2.2%), Улаанбаатар хотод 23 (51.1%), Улаанбаатар төмөр замд 1 (2.2%) тохиолдол бүртгэгдсэн байна.

Зураг 2. Осолдогчид, насны бүлгээр, дүнд эзлэх хувиар, 2021 оны эхний улиралд




Осолдогчдыг насны бүлгээр авч үзэхэд 18-24 насных 5 (11.1%), 25-34 насных 15 (33.3%), 35-44 насных 12 (26.7%), 45-59 насных 13 (28.9%) байна.

Хүснэгт 1. Осолдогчид, эдийн засгийн үйл ажиллагааны салбараар, жил бүрийн эхний улиралд

Салбар	2019	2020	2021
	I-III	I-III	I-III
Дүн	66	84	45
Хөдөө аж ахуй, ойн аж ахуй, загас барилт, ан агнуур	1	3	1
Уул уурхай, олборлолт	18	17	3
Боловсруулах үйлдвэрлэл	3	10	9
Цахилгаан, хий, уур, агааржуулалт	6	2	1
Усан хангамж, бохир ус зайлуулах систем, хог, хаягдлын менежмент болон цэвэрлэх үйл ажиллагаа	3	-	1
Барилга	4	-	1
Бөөний болон жижиглэн худалдаа, машин, мотоциклийн засвар үйлчилгээ	2	4	1
Тээвэр ба агуулахын үйл ажиллагаа	6	18	2
Зочид буудал, байр, сууц болон нийтийн хоолны үйлчилгээ	1	-	2
Мэдээлэл, холбоо	-	-	1
Санхүүгийн болон даатгалын үйл ажиллагаа	2	1	-
Үл хөдлөх хөрөнгийн үйл ажиллагаа	-	-	-
Мэргэжлийн шинжлэх ухаан болон техникийн үйл ажиллагаа	1	-	-
Удирдлагын болон дэмжлэг үзүүлэх үйл ажиллагаа	-	-	1
Төрийн удирдлага ба батлан хамгаалах үйл ажиллагаа, албан журмын нийгмийн хамгаалал	6	13	9
Боловсрол	3	6	-
Хүний эрүүл мэнд ба нийгмийн халамжийн үйл ажиллагаа	4	6	6
Урлаг, үзвэр, тоглоом наадам	-	-	-
Үйлчилгээний бусад үйл ажиллагаа	6	4	7
Хүн хөлслөн ажиллуулдаг өрхийн үйл ажиллагаа	-	-	-
Олон улсын байгууллага, суурин төлөөлөгчийн үйл ажиллагаа	-	-	-

Нийт осолдогчдыг эрхэлж байсан ажил мэргэжлээр нь авч үзвэл, энгийн ажил мэргэжлээр 17 (37.8%), суурин төхөөрөмж, машин механизмын операторч, угсрагчаар 7 (15.6%) , зэвсэгт хүчний ажил, мэргэжил болон үйлдвэрлэл, барилга, гар урлал, холбогдох ажил, үйлчилгээний ажилтнаар 6 (13.3%), техникч болон туслах, дэд мэргэжилтнээр 3 (6.8%), мэргэжилтэн болон контор, үйлчилгээний ажилтнаар тус бүр 2 (4.4%), менежер болон худалдаа, үйлчилгээний ажилтнаар тус бүр 1 (2.2%) нь ажилласан байна.

Зураг 3. Осолдогчид, ажил мэргэжлээр, дүнд эзлэх хувиар 2021 оны эхний улиралд



Ойлголт, тодорхойлолт:

Үйлдвэрлэлийн осол: гэж хөдөлмөр эрхлэгч иргэн хөдөлмөрлөх үүргээ биелүүлэх явцад үйлдвэрлэлийн болон түүнтэй адилтгах хүчин зүйлийн үйлчлэлд өртөхийг ойлгоно.

Хурц хордлого: гэж цацраг болон биологийн идэвхт бодис, химийн хорт бодисын нөлөөгөөр хурц, цочмог хэлбэрээр богино хугацаанд хордохыг ойлгоно.

Осолдогч: гэж үйлдвэрлэлийн осол, хурц хордлогод өртсөн ажилтан, иргэнийг ойлгоно.  
Үйлдвэрлэлийн осол, хурц хордлогод өртсөн нэг ажилтан, иргэнийг үйлдвэрлэлийн осол, хурц хордлогын нэг тохиолдол гэж үзнэ. Хэрвээ нэг осол, хордлогод нэгээс дээш тооны хүн өртсөн бол осолдогч тус бүрээр үйлдвэрлэлийн осол, хурц хордлогын тохиолдол гэж тооцно.  
Бүлэг осол, хурц хордлого: гэж нэг үйлдвэрлэлийн осол, хурц хордлогод 2, түүнээс дээш тооны ажилтан, иргэн өртөхийг ойлгоно.

Эх үүсвэр: Мэргэжлийн хяналтын ерөнхий газар

Ангилал, код: ISCO-08 - ажил, мэргэжлийн ангилал, ISIC-4 - эдийн засгийн бүх төрлийн үйл ажиллагааны салбарын ангилал, ICD-10- өвчний олон улсын ангилал.

Мэдээлэл авах линкүүд:

<http://www.nso.mn/>

<http://www.1212.mn/>

Дараагийн мэдээ тархаах хуваарь: 2020 оны 7 дугаар сарын 16



Хүн ам, нийгмийн статистикийн  
газрын статистикч Н. Алтантүлхүүр  
Утас : (976-51)-265543

Хүн ам, нийгмийн статистикийн газрын дарга  
А.Амарбал  
Утас : (976-51)-264805